

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА

ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: 2020-2021 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалт

Хамрагдсан байгууллага: Налайх Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк
ОНӨААТҮГ

Улаанбаатар хот

2022 он

АГУУЛГА

| | |
|--|----|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ | 3 |
| ТАНИЛЦУУЛГА..... | 4 |
| ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО ХАМРАХ ХҮРЭЭ..... | 4 |
| ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН..... | 6 |
| Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар..... | 6 |
| Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар..... | 7 |
| ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ..... | 11 |
| ДҮГНЭЛТ | 11 |
| ЗӨВЛӨМЖ..... | 12 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------------|---|
| Товч | Дэлгэрэнгүй |
| НИТХТ | Нийтслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид |
| ОНӨТҮГ | Орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| НБМУТП | Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| ТБОНӨХБАУХАТ | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай |

ТАНИЛЦУУЛГА

НИТХТ 2014 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 148 дугаар тогтоолоор “Налайхын Барилгын материалын Үйлдвэрлэл, технологийн парк” Орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газрыг (ОНӨААТҮГ) байгуулж, дүрмийг батласан байна. Нийслэлий Засаг даргын (НЗД) 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/1047 дугаар захирамжаар бүтэц, орон тоог 14 албан хаагчтай байхаар батласан байна.

Тус газрын дүрмэнд “Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг НЗД-ын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт парк байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий газар гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь 5890683 регистрийн дугаартай, нийслэлийн төрийн сан дахь үндсэн үйл ажиллагааны 100200051099, нэмэлт санхүүжилтийн 100200051468, данснуудаар төлбөр тооцоог хийж ирсэн байна.

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоог хийхэд нэгдүгээр гарын үсгийг С.Батжаргал хоёрдугаар гарын үсгийг ахлах нягтлан бодогч Ц.Бямбасүрэн 2021 оны 03 дугаар сарын 16 хүртэл, 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс Г.Ганцэцэг нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО ХАМРАХ ХҮРЭЭ

Аудит хийх үндэслэл, бүрэлдэхүүн

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, нийслэлийн Дотоод аудитын газрын “Аудит, хяналт шалгалтын 2022 оны төлөвлөгөө”, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталсан 07 дүгээр удирдамжийн дагуу Налайх Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ-ын 2020-2021 оны үйл ажиллагаанд 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийг дуусталх хугацаанд Дотоод аудитор /СХШУБ/ Т.Ариунцэцэг дотоод аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Зорилго

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк (НБМУТП) ОНӨААТҮГ засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдал төсөв, санхүү, өмч хөрөнгөтэй о үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, журамтай хэр нийцэж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангахад оршино.

Хамрах хүрээ:

Дотоод аудит, хяналт шалгалтын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

Дотоод аудит:

- засаглал;
- эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;
- шилэн дансны тухай хууль тогтоомж;

Хяналт шалгалт:

Санхүүгийн хяналт шалгалтад тус газрын 2020-2021 оны дараах үйл ажиллагааг хамруулан шалгалаа. Үүнд:

- Санхүү, төсөв, өмч, нягтлан бodoх бүртгэлийн холбогдолтой хууль, тогтоомж, түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;
- Худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа;
- Байгууллагын дотоод журам, удирдлагын тушаал, бусад байгууллага хувь хүнтэй байгуулсан гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Батлагдсан төсөв, зорилтот түвшин түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал;
- Тус байгууллагын бүтэц орон тоо, цалин хөлсний тогтоолт олгосон байдал;
- Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, олж бэлтгэсэн байдал;
- Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;
- Төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;
- Анхан шатны болон нягтлан бodoх бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, боловсруулалт, санхүүгийн мэдээ, тайлан гаргалтын байдал;
- Гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ногдол ашиг зэрэг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн төвлөрүүлэлтийн байдал;
- Байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлтийг хамруулан шалгалаа.

Тус байгууллагын 2020 он, 2021 оны төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах үйл ажиллагааг хамруулж, аудитын зорилго, зорилтой холбогдуулан дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болголоо. Үүнд:

- Төсвийн тухай хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн (НББ) тухай хууль болон холбогдох бусад хуулиуд, тэдгээрт нийцсэн төрийн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан заавар, журам, тогтоол, шийдвэрүүд; .
- Дотоод аудитын олон улсын стандарт, санхүүгийн хяналт шалгалтын стандарт;
- 2020 он, 2021 оны санхүүгийн тайлан, тодруулга, журналууд;
- Анхан шатны болон НББ-ийн баримт бичгүүд;
- Гэрээ, ажлын гүйцэтгэлүүд гэх мэт бусад материалууд.

Хамрах хүрээний хязгаарлалт: Байхгүй

Өмнөх шалгалтын талаар:

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь НБМУТП ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт,

Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан тул зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар

Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг:

НБМУТП ОНӨААТҮГ нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаар дүрмэнд тусгасан. Үүнд:

- Нийгэм эдийн засаг, байгаль орчны зохистой харьцааг хангах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх замаар, төлөвлөгдсөн газрыг паркийн бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;
- Хариуцсан ажил үүргийн чиглэлээр паркийн бүсийг хөгжүүлэх орчноо тохижуулах үйл ажиллагаанд хувийн хэвшил, холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог ханган, тэдний санал санаачлагыг хөгжлийн төсөл, хөтөлбөрт тусгах, хамтран ажиллах;
- Үйлдвэрлэл, технологийн паркийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нарийвчилж тооцсон хөгжлийн үе шатны төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцон Удирдах зөвлөлөөр оруулж батлуулах;
- Паркийн дэд бүтцийн техникийн нөхцлүүдийг нарийвчлан судалж, холбогдох бичиг баримт материалууд, зураг, схемүүдийг бүрдүүлж, паркийн эрчим хүч, дулаан, усан хангамж зэргийн хэрэглээний нийт тооцоог гаргаж, хот байгуулалт, инженерийн байгууламжийн төлөвлөгөөтэй уялдуулан инженерийн тооцоо зураглал боловсруулах ажлыг зохион байгуулах.

Тушаал, шийдвэрийн талаар:

Тус газар нь 2020 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 45 "А", боловсон хүчиний чиглэлээр 44 "Б", 2021 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 17 "А", боловсон хүчиний чиглэлээр 40 "Б" нийт 146 тушаал төлөвлөж гаргасан байна.

Бүтэц орон тооны талаар:

НЗД-ын 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/1047 дугаар захирамжаар 14 албан хаагчтайгаар баталсан байна.

Хүснэгт 1.

Бүтэц, орон тоо

| № | Албан тушаалын нэр | Тоо | Гүйцэтгэл | |
|----|---|-----|-----------|------|
| | | | 2020 | 2021 |
| 1 | Дарга | 1 | 1 | 1 |
| 2 | Ахлах мэргэжилтэн | 1 | 1 | 1 |
| 3 | Ахлах нягтлан бодогч | 1 | 1 | 1 |
| 4 | Инженер | 1 | 1 | 1 |
| 5 | Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн | 1 | 1 | 1 |
| 6 | Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн | 1 | 1 | 1 |
| 7 | Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн | 2 | 2 | 2 |
| 8 | Маркетинг, ОНХХ хариуцсан мэргэжилтэн | 1 | 1 | 1 |
| 9 | Хуулийн мэргэжилтэн | 1 | 1 | 1 |
| 10 | Захиргааны ажилтан | 1 | 1 | 1 |
| 11 | Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн | 1 | 1 | 1 |
| 12 | Нярав | 1 | 1 | 1 |
| 13 | Жолооч | 1 | 1 | 1 |

Тус газар нь 2020 онд 6 албан хаагч шинээр томилж, 4 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна. Мөн 2021 онд 3 албан хаагч шинээр томилж, 2 албан хаагч өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдж, 1 албан хаагч жирэмсний амралтаа авсан байна.

Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явц:

Байгууллагын даргын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/23 дугаар тушаалаар “Байгууллагын дотоод хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх журам” баталсан хэдий ч шалгалтанд хамрагдах хугацаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Зорилт 2. Санхүүгийн үйл ажиллагааны талаар

Санхүүгийн тайлангийн талаар

НБМУТП ОНӨААТҮГ нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд 28,509.2 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 22,892,364.2 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, нийт 22,920,873.4 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

Тайлант 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд 30,588.2 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 58,025,263.7 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, нийт 58,055,851.9 мянган төгрөгийн хөрөнгө тайлагнасан байна.

Хүснэгт 2

Санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | 2019.12.31 | 2020.12.31 | 2021.12.31 |
|--|---------------------|---------------------|---------------------|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 29,579.3 | 28,509.2 | 30,588.2 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | | | |
| Авлага | 12,349.1 | 12,349.1 | 10,349.1 |
| Байгууллагаас авах авлага | 7,888.0 | 7,888.0 | 7,888.0 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 4,461.1 | 4,461.1 | 2,461.1 |
| Бараа материал | 17,230.2 | 16,160.1 | 20,239.0 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 22,915,064.5 | 22,892,364.2 | 58,025,263.7 |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 22,915,064.5 | 22,892,364.2 | 58,025,263.7 |
| Биет хөрөнгө | 675,388.5 | 652,803.2 | 639,207.2 |
| Биет бус хөрөнгө | 22,239,676.0 | 22,239,561.0 | 57,386,056.5 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 22,944,643.8 | 22,920,873.4 | 58,055,851.9 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 86.0 | 7,286.0 | 149.0 |
| Богино хугацаат өр төлбөр | 86.0 | 7,286.0 | 149.0 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 22,944,557.8 | 22,913,587.4 | 58,055,702.9 |
| Төрийн өмч | 22,238,296.0 | 22,238,296.0 | 22,238,296.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 706,261.8 | 675,291.4 | 35,817,406.9 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 22,944,643.8 | 22,920,873.4 | 58,055,851.9 |

Авлагын талаар

НИТХТ-ийн 2014 оны 200 дугаар тогтоолын дагуу НЗД-ын 2014 оны А/1016 дугаар захирамжаар батлагдсан татан буулгах комиссоос Улаанбаатар бизнес хөгжлийн төв ОНӨААТҮГ-ын нийт 13,349,1 мянган төгрөгийн авлагыг НБМУТП ОНӨААТҮГ-т актаар 2015 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн байна. Тайланд 2021 онд 2,000.0 мянган төгрөгийн авлага барагдсан байна. Бусад авлага нь эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагууд байна.

Бараа материалын талаар

НБМУТП ОНӨААТҮГ нь 2020 онд 14,881.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 15,951.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 16,160.1 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнасан байна. Тайлант 2021 онд 22,921.1 мянган төгрөгийн

бараа материал худалдан авч, 18,842.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 20,239.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тайлагнасан байна.

Хүснэгт 3

Бараа материалын хөдөлгөөний тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр | 2020.12.31 | | | | 2021.12.31 | | |
|------|---------------------------------|-------------------|----------|----------|--------------------|------------|----------|--------------------|
| | | Эхний үлдэгдэл | Орлого | Зарлага | Эцсийн үлдэгдэл | Орлого | Зарлага | Эцсийн үлдэгдэл |
| 1 | Дуусаагүй үйлдвэрлэл | 13,000.0 | | | 13,000.0 | 0.0 | 0.0 | 13,000.0 |
| 2 | Бичиг хэргийн материал | 483.2 | 4,792.5 | 4,747.6 | 528.1 | 4,903.8 | 3,800.5 | 1,631.4 |
| 3 | Аж ахуйн материал | 1,726.9 | 1,814.1 | 2,904.0 | 637.0 | 6,227.3 | 3,784.1 | 3,080.2 |
| 4 | Сэлбэг хэрэгсэл | | 75.0 | 75.0 | 0.0 | 110.0 | 110.0 | 0.0 |
| 5 | Түлш, шатах тоослох материал | 2,020.0 | 8,200.0 | 8,225.0 | 1,995.0 | 11,680.0 | 11,147.5 | 2,527.5 |
| Нийт | | 17,230.1 | 14,881.6 | 15,951.6 | 16,160.1 | 22,921.1 | 18,842.1 | 20,239.1 |

Үндсэн хөрөнгийн талаар:

Тус байгууллага нь 2020 оны эхэнд 23,059,296.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээс 166,932.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж, 22,892,364.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2021 онд эхэнд 23,059,296.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсанаас 35,154,826.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 188,859.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж, 58,025,263.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна

Хүснэгт 4

Үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | 2020 он | | | 2021 он | | |
|----------|---------------------------|-------------------|-------------|--------------|--------------|-------------|--------------|
| | | Эхний үлдэгдэл | Хур.элэгдэл | Үлдэх өртөг | Нэмэгдсэн | Хур.элэгдэл | Үлдэх өртөг |
| 1 | Барилга байгууламж | 725,673.4 | 79,690.3 | 645,983.1 | | 97,832.1 | 627,841.3 |
| 2 | Авто тээврийн хэрэгсэл | 21,280.0 | 21,280.0 | 0.0 | | 21,280.0 | 0.0 |
| 3 | Тоног төхөөрөмж | 37,909.0 | 35,792.5 | 2,116.5 | 8,101.0 | 37,743.6 | 8,266.4 |
| 4 | Тавилга эд хогшил | 30,991.1 | 26,685.1 | 4,306.0 | | 28,241.3 | 2,749.8 |
| 5 | Бусад үндсэн хөрөнгө | 1,276.8 | 879.3 | 397.5 | | 927.0 | 349.8 |
| 6 | Программ хангамж | 3,870.0 | 2,605.0 | 1,265.0 | | 2,835.0 | 1,035.0 |
| 7 | Бусад биет бус хөрөнгө | 22,238,296.0 | 0.0 | 22,238,296.0 | 35,146,725.5 | 0.0 | 57,385,021.5 |
| Нийт дүн | | 23,059,296.3 | 166,932.2 | 22,892,364.1 | 35,154,826.5 | 188,859.0 | 58,025,263.8 |

Тус байгууллага нь НЭД-ын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/452 дугаар захирамжаар Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо Улаанхуаранд 0.04 га 9 ба түүнээс дээш давхар орон сууцны зориулалтаар, НЭД-ын 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/344 дугаар шийдвэрээр Налайхын 3-р хороонд 120 га Үйлдвэрлэл технологийн парк зориулалтаар, НЭД-ын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/526 дугаар захирамжаар Налайх 3 дугаар хороонд 130 га Үйлдвэрлэл технологийн зориулалтаар, НЭД-ын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/1081 дугаар захирамжаар Налайх 3 дугаар хороонд 60 га үйлдвэрлэл технологийн паркийн зориулалтаар тус тус эзэмшиж байна.

Газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/13 дугаар тушаалаар нийт 8,101.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар:

Тус газар нь 2020 онд орон нутгийн төсвөөс 342,261.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 342,261.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд нийт 313,632.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тайлант 2021 онд орон нутгийн төсвөөс 341,532.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 341,532.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд нийт 317,440.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 7

Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Зардлын үзүүлэлт | 2020 он | | | 2021 он | | |
|----|---|------------|-----------|------------------|------------|-----------|------------------|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэтрэлт, хэмнэлт |
| | Урсгал зардлын дүн | 342,261.0 | 313,632.4 | 29,828 | 341,532.9 | 317,440.9 | 24,092.0 |
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 196,540.0 | 195,890.4 | 649.6 | 185,990.0 | 185,925.2 | 64.8 |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 26,532.9 | 24,476.8 | 2,056.1 | 25,108.7 | 25,108.4 | 0.3 |
| 3 | Гэрэл цахилгаан | 32,730.9 | 21,831.4 | 10,899.5 | 43,522.0 | 21,326.1 | 22,195.9 |
| 5 | Цэвэр, бохир ус | 7,680.0 | 7,677.4 | 2.6 | 7,680.0 | 7,680.0 | 0.0 |
| 7 | Бичиг хэрэг | 5,300.0 | 4,792.5 | 507.5 | 5,035.0 | 5,034.5 | 0.5 |
| 8 | Тээвэр /шатахуун/ | 11,680.0 | 10,969.8 | 710.2 | 11,680.0 | 11,680.0 | 0.0 |
| 9 | Шуудан холбоо, интернет | 5,544.0 | 4,972.6 | 571.4 | 5,544.0 | 4,621.2 | 922.8 |
| 10 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал | 1,700.0 | 190.0 | 1,510.0 | 1,700.0 | 400.0 | 1,300.0 |
| 11 | Бага үнэтэй түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,000.0 | 968.3 | 31.7 | 1,000.0 | 1,393.3 | -393.3 |
| 12 | Эд хогшил худалдан авах | 1,955.0 | 755.8 | 1,199.2 | | | |
| 13 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 1,755.0 | 592.8 | 1,162.2 | 1,755.0 | 1,754.3 | 0.7 |
| 14 | Томиололт | | | | 1,000.0 | 1,000.0 | 0.0 |
| 15 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 49,118.2 | 39,207.2 | 9,911.0 | 51,018.2 | 51,018.0 | 0.2 |
| 16 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 480.0 | | 480.0 | | | |
| 17 | Урсгал засвар | 200.0 | 163.0 | 37.0 | | | |
| 18 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 2,000.0 | 1,900.0 | 100.0 | 500.0 | 500.0 | 0.0 |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 342,261.0 | 313,632.4 | 28,628.6 | 341,532.9 | 317,441.0 | 24,091.9 |

Төсвийн гүйцэтгэлээс харахад 2020 онд нийт зардлын 62.4 хувийг цалин, 7.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, 6.9 хувийг гэрэл цахилгаан, 12.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 10.4 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Гэрэл цахилгааны зардлыг 10,899.5 мянган төгрөгөөр хэмнэсэн нь ковид 19-өөс шалтгаалан kontорын барилгын цахилгааны төлбөр бага гарсанаас шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс харахад 2021 онд нийт зардлын 58.6 хувийг цалин, 7.9 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, 6.7 хувийг гэрэл цахилгаан, 16.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 10.8 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Гэрэл цахилгааны зардлыг 22,195.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь ковид 19-өөс шалтгаалан kontорын барилгын цахилгааны төлбөр бага гарсанаас шалтгаалсан байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

Тайлант 2021 онд Пийс стиил групп ХХК-аас тог цахилгаан, худаг ус, усны тоног төхөөрөмж ашигласаны төлбөр болох нийт 24,474.0 мянган төгрөг, иргэн н.Сайханбаяраас авах авлага 2,000.0 мянган төгрөг орж ирсэн байна. Тус газар нь байгууллагын гүний худгийн тоног төхөөрөмж, насос, ус зөөх, нөөцлөх сав хуучирч муудан эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа тул тэдгээрийг засварлах мөн гүний худгийн орчимд камержуулалт хийх шаардлагатай болж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст зарцуулах эрх нээлгэж 12,268.4 мянган төгрөгөөр шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авч, 12,205.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын талаар

Тус газарт 2014-2022 оны байдлаар Барилга хот байгуулалтын яамын санхүүжилтээр 2,434.8 мянган төгрөгийн, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17,938.8 мянган төгрөгийн нийт 20,373.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.

НБМУТП ОНӨААТҮГ-т 2014-2022 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлууд

| № | Ажлын нэр | Хугацаа /он/ | ХО /сая төгрөг/ | Эх үүсвэр |
|-------------------------|--|--------------|------------------|------------------|
| 1 | Паркийн техник эдийн засгийн үндэслэл | 2014 | 350.0 | Нийслэлийн төсөв |
| 2 | 110/10кВ-ийн дэд станц, ажлын зураг төсөл | 2015 | 150.0 | Нийслэлийн төсөв |
| 3 | Бүтээн байгуулалтын үеийн цахилгаан хангамжийн ажил | 2015 | 458.0 | Нийслэлийн төсөв |
| 4 | Усны нөөц тогтоох гидрогеологийн ажил | 2015 | 350.0 | Нийслэлийн төсөв |
| 5 | Оффисын барилга /660 м2/ | 2015 | 672.0 | Нийслэлийн төсөв |
| 6 | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | 2016 | 180.0 | Нийслэлийн төсөв |
| 7 | Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ /Бтөсөл/ | 2016 | 180.0 | Нийслэлийн төсөв |
| 8 | Сайжруулсан шороон зам /2 км/ | 2016 | 120.0 | Нийслэлийн төсөв |
| 9 | Гүний худаг /2 ш/ | 2016 | 44.0 | Нийслэлийн төсөв |
| 10 | Дэд бутцийн бүх зураг төслүүд хийгдсэн | 2017 | 1,128.0 | БХБЯам |
| 11 | Үерийн далангийн ажил 1,65км 40% | 2018 | 250.0 | БХБЯам |
| 12 | Налайх Чойрын чиглэлийн авто замтай холбох 4,64 км авто зам /Бетон хүчилттэй 4этнээ/ 30% | 2018 | 1,800.0 | Нийслэлийн төсөв |
| 13 | 1,65 км үерийн барилга байгууламж 85% | 2019 | 828.0 | БХБЯам |
| 14 | 4,64 км авто замын ажил 90% | 2019 | 1,513.8 | Нийслэлийн төсөв |
| 15 | Цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төслийн өөрчлөлтийн зураг | 2019 | 28.9 | Нийслэлийн төсөв |
| 16 | Авто замтай холбох 4,64 км авто зам /Бетон хүчилттэй 4 этнээ/ | 2020 | 5,513.7 | Нийслэлийн төсөв |
| 17 | Цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил /1-р ээлж/ | 2020 | 2,100.0 | Нийслэлийн төсөв |
| 18 | Цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил /2-р ээлж/ | 2020 | 100.0 | Нийслэлийн төсөв |
| 19 | Цахилгаан хангамжийн тоног төхөөрөмж сууринтуулалт /1-р ээлж/ | 2021 | 400.0 | Нийслэлийн төсөв |
| 20 | Цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил /2-р ээлж/ | 2021 | 400.0 | Нийслэлийн төсөв |
| 21 | Паркийн өргөтгөл 130 га газрын Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | 2021 | 228.8 | БХБЯ |
| 22 | Цахилгаан хангамжийн тоног төхөөрөмж сууринтуулалт /1-р ээлж/ | 2022 | 497.4 | Нийслэлийн төсөв |
| 23 | Цахилгаан хангамжийн барилга угсралт, тоног төхөөрөмж. ажил /2-р ээлж/ | 2022 | 3,080.8 | Нийслэлийн төсөв |
| Нийт | | | 20,373.64 | |
| Улсын төсөв | | | 2,434.8 | |
| Нийслэлийн төсөв | | | 17,938.84 | |

НИТХТ-ийн 2016 оны 4 дүгээр сарын 05-ний өдрийн 52 тоот тогтоолоор батлагдсан тус паркийн 120 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу паркийн үндсэн цахилгаан хангамжийн барилга байгууламжийн угсралтын ажил нийт 14,520,928.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд тус ажлын тендер шалгаруулалт зохион байгуулагдаж нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд эхэлсэн боловч хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдээгүйн улмаас 4 жил дамнан гүйцэтгэгдэж байна.

Одоогийн байдлаар уг ажилд нийслэлийн төсвөөс 2,999,537.3 мянган төгрөгөөр санхүүжигдсэн бөгөөд нийт ажил 35 хувийн гүйцэтгэлтэй байна.

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

1. Тус газар нь дүрмийн 2.3-т “Үйлдвэрлэл, технологийн паркийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нарийвчлан тооцсон хөгжлийн үе шатын төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг тооцон Удирдах Зөвлөлөөр оруулж батлуулах” гэж заасан боловч дотоод аудит, хяналт шалгалтын хамрагдах хугацаанд Удирдах зөвлөлгүй ажилласан байна.
2. НИТХТ 2014 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 148 дугаар тогтоолоор “Налайхын Барилгын материалын Үйлдвэрлэл, технологийн парк” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсугай гэсэн боловч 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Улсын бүртгэлийн гэрчилгээг аваадаа ОНӨААТҮГ гэсэн статустай гэрчилгээг гаргуулж авсан байна.
3. Улаанбаатар бизнес хөгжлийн төвөөс шилжиж ирсэн эзэн холбогдогч нь тодорхойгүй 10,349.1 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн “20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ: ...20.2.5 ; дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; заалтыг зөрчсөн.
4. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйл. Гэрээ шууд байгуулах арга 34.1-д “Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно: 34.1.1. “энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд”, хуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан аваад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.”, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах гэж заасан. Гэтэл Лхагвасүрэн бөх тулга ХХК-тай 2020 онд 43,200.0 мянган төгрөгийн, 2021 онд 43,200.0 мянган төгрөгийн харуул хамгаалалтын ажлын гэрээг шууд байгуулсан байна.

ДҮГНЭЛТ

“Налайхын Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ-ийн удирдлага, санхүүгийн ажилтнууд нь санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, эрх зүйн актын дагуу тайлагнасан байна.

Дүрэмд эд хөрөнгийн эрхийн ангилал ОНӨААТҮГ, байгууллагын гэрчилгээ нь ОНӨААТҮГ гэсэн статустай байна.

Паркийн гишүүн аж, ахуйн нэгж байгууллагууд нь олгогдсон газар дээрээ үйлдвэрлэлийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулахад цахилгаан хангамжийн эх үүсвэрээс шатгаалан зогсонги байдалтай байна.

Тус газар нь дотоод аудит, хяналт шалгалтаар байгууллагын засаглалтай холбоотой илэрсэн асуудалд 2 зөвлөмж, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 96,749.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг өгч байна.

Дотоод аудит, хяналт шалгалтаар танай байгууллагад "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч байна.

ЗӨВЛӨМЖ

Дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд

1. Дүрмэнд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах;
2. Өглөг, авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах;
3. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйл. Гэрээ шууд байгуулах арга 34.1 "Гэрээ шууд байгуулах аргыг зөвхөн дараах нөхцөлд хэрэглэж болно: 34.1.1. "энэ хуулийн 30.4.3, 36.18-д заасан тохиолдолд заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг нийслэлийн Дотоод аудитын албан дирүүлэхийг мэдэгдэж байна.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА

ХЯНАСАН:
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

АУДИТ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДОТООД АУДИТОР /СХШУБ/

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:
НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛӨЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ-ИЙН ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ



Б.ЖАВЗАН

Ч.ГУРБАЗАР

Т.АРИУНЦЭЦЭГ



С.БАТЖАРГАЛ

Г.ГАНЦЭЦЭГ